



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

**「Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний
чиглэлийн замналд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны иргэдийн санал хүсэлт, зорчих эрэлтэд үндэслэн ХО:10 “Эмээлт /хурган/-Хархорин-10-р хороолол” чиглэлийн замналд өөрчлөлт оруулж хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх чиглэлийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг боловсруулж 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс үйлчилгээг эхлүүлэн нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, тухайн чиглэлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн тээврийн газрын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/72 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР

